



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар A/527

Улаанбаатар хот

「 Баянзүрх дүүргийн 61 дүгээр цэцэрлэгийн
хөрөнгө данснаас дансанд шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны A/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар

хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 5,240,700.0 (таван сая хоёр зуун дөчин мянга долоон зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг

хавсралтын дагуу холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Баянзүрх дүүргийн 61

дүгээр цэцэрлэг (Х.Мөнгөнтуяа)-т зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн 61 дүгээр цэцэрлэг (Х.Мөнгөнтуяа)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.